

Дөрөв: АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАСНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1	<p>Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага MNS 13688:2000” Монгол улсын стандарттай дүйцэхүйц шаардлагыг хангасан байх.</p>	<p>Хувцасны материал нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажсан байна.</p> <p>Хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь хүнд саад болохгүй байх</p> <p>Хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байх</p> <p>Ажлын тусгай хувцсыг үйлдвэрлэснээс хойш 2-оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх</p>
2	<p>Ажилтнуудын хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага</p>	<p>Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх</p> <p>Ус, тос, масло нэвтрүүлэхгүй байх</p> <p>Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт өгөхгүй.</p> <p>Цахилгаанжихгүй, болзошгүй цахилгаан нумын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байна.</p> <p>Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник, элементүүдэд орооцолдохгүй байх</p>
3	<p>Ажлын тусгай хувцасны бүтэц, оруулга</p>	<p>Өвдөг тохой, өгзөгийн хэсгээр нэмэлт давхарлагаатай байна</p> <p>Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна. Өмд өвдөг хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна.</p> <p>Гэрэлтдэг оруулгын өнгө саарал байна.</p> <p>Гэрэлтдэг оруулгын дээд талд ЧАНДМАНЬ-ИЛЧ гэсэн ширээстэй бичгийг бор өнгөөр хийх</p> <p>Үндсэн өнгө Инженер техникийн ажилтнуудынх цагаан саарал өнгөн дээр хар ногоон оруулгатай, ажилчдынх хөх өнгөн дээр цэнхэр оруулгатай, материал байна.</p> <p>Ажилчдын хувцасны ар талын нуруун дээр Чандмань-Илч гэсэн ширээсэн бичигтэй, зүүн талын энгэр дээр байгууллагын лого байна.</p> <p>Ажлын зуны тусгай хувцасыг өнгө дагуу товчтой хийнэ.</p> <p>Хэрэглэгч байгууллагын хүссэн загвараар хийж гүйцэтгэх</p>